



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 05 сарын 05 өдөр

Дугаар 17

Улаанбаатар хот

XVII ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Зохион байгуулалт: Улсын онцгой комиссын хуралдаан 2021 оны 5 дугаар сарын 05-ны өдрийн 18.00 цагт Төрийн ордны “А” танхимд хуралдав.

Хурлыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга С.Амарсайхан даргалж, холбогдох шийдвэрийг гаргаж, хугацаатай үүрэг даалгавар өгөв.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

1. “Коронавируст халдвар (Ковид-19)-ын тархалтын түвшин тогтоох, хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохицуулах түр журам”-ын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай:

*Танилцуулах нь: Улсын онцгой комиссын нарийн бичгийн дарга,
хурандаа Ж.Амгалан,*

2. “Гэрийн болон тусгаарлан ажиглалтын үйл ажиллагааг зохицуулах түр журам, Хот хоорондын зорчигч тээвэрлэлтийг зохицуулах түр журам”-ын нэмэлт өөрчлөлтийн талаар:

*Танилцуулах нь: Онцгой байдлын ерөнхий газрын дэд дарга,
Шуурхай штабын дарга, хурандаа Ц.Ганзориг,*

3. “Коронавируст халдвар (Ковид-19)-аас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах түр журам-ын өөрчлөлт

*Танилцуулах нь: Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дэд дарга,
Г.Сугарбат*

УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН 2021 ОНЫ 5 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДРИЙН 17
ДУГААР ХУРАЛДААНЫ ШИЙДВЭР

Улсын онцгой комиссын 17 дугаар хуралдаан 2021 оны 5 дугаар сарын 05-ны өдрийн 18.00 цагаас Төрийн ордонд хуралдаж, хуралдаанаас дараах шийдвэрийг гаргаж хэрэгжүүлэхээр тогтов.

Нэг. Улсын онцгой комиссын гишүүд, агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Онцгой комиссын дарга нарт:

1.1. Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 115 дугаар тогтоолоор улсын хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдлын “Улбар шар” түвшинд шилжүүлсэнтэй холбогдуулан төрийн байгууллага, хуулийн этгээд, хүний үйл ажиллагааны зохицуулалтыг батлагдсан журамд заасны дагуу зөв зохион байгуулж, халдвар тархахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг шуурхай зохион байгуулж ажиллах;

1.2. “Коронавируст халдвар (КОВИД-19)-аас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах түр журам”, “Хот хоорондын зорчигч тээвэрлэлтийг зохицуулах түр журам” “Гэрийн болон тусгаарлан ажиглалтын үйл ажиллагааг зохицуулах түр журам”-уудад тусгах саналаа 2021 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн 12:00 цагаас өмнө Улсын онцгой комиссын ажлын албанд ирүүлэх;

1.3. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тархалтын түвшин тогтоох, хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохицуулах түр журам”, “Коронавируст халдвар (КОВИД-19)-аас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах түр журам”, “Хот хоорондын зорчигч тээвэрлэлтийг зохицуулах түр журам” “Гэрийн болон тусгаарлан ажиглалтын үйл ажиллагааг зохицуулах түр журам”-уудыг мөрдүүлж, хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллах;

*Хоёр. Улсын онцгой комиссын гишүүн, Эрүүл мэндийн сайд С.Энхболд,
ЗГХЭГ-ын хэвлэл мэдээлэлтэй харилцах газрын дарга Ц.Ганзориг, Аймаг,
нийслэлийн Засаг дарга нарт:*

2.1. Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх хариу арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, хувийн хамгаалах хэрэгсэл, оношлуур, халдваргүйтгэлийн бодисын нөөцийг нарийвчилан тооцож, шаардлагатай нөөц бүрдүүлж, ашиглалт хэрэглээнд хяналт тавих;

2.2. Коронавируст халдвар (Ковид-19)-ын эсрэг вакцинжуулалтын ажлыг улсын хэмжээнд эрчимжүүлж, вакцинжуулалтад иргэдийг хамруулах ажлыг идэвхижүүлэх, иргэд олон нийтэд нээлттэй мэдээллэх ажлыг зохион байгуулах;

2.3. Улаанбаатар хотод дархалаажуулах цэгийн ажиллах цагийн хуваарийг 22:00 цаг хүртэл сунгаж, дархлаажуулалтын явуулын цэгийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, нийслэлийн хүн амын дархлаажуулалтын 1 дүгээр тунг 2021 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн дотор, улсын хэмжээнд 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор хамруулж дуусгах ажлыг шуурхай зохион байгуулах;

2.4. Гэрийн тусгаарлалтад байгаа иргэдийг бүртгэх, хяналт тавих, ойрын хавьтлыг халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлийн зөвлөмж, зөвлөлгөөг иргэн бүрт хүргэж шаардлагатай эм, эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх ажлыг тасалдалгүй зохион байгуулах;

Гурав. Улсын онцгой комиссын гишүүн Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Т.Гантулга, Цагдаагийн ерөнхий газрын дарга, цагдаагийн хурандаа Ж.Болд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар нарт:

3.1. “Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тархалтын “Улбар шар түвшин”-д зарим хуулийн этгээдийн салбар чиглэлийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулж, шаардлагатай тохиолдолд хэсэгчилсэн хязгаарлалтыг түр хугацаагаар хийх;

3.2. Бүртгэлийн цахим системийн QR код байршуулаагүй, халдвар хамгааллын дэглэм, холбогдох дүрэм журам мөрдөөгүй аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг зогсоох хүртэл арга хэмжээг авч ажиллах;

3.3. Хүнсний зах, худалдааны төв, их дэлгүүр, агуулах худалдаа, хайпермаркетын ажилтан, алба хаагчид, түрээслэгчдийг коронавируст халдвар (Ковид-19)-ын эсрэг дархлаажуулалтын бүрэн тунд хамрагдсан болон өвчилж эдгэрсэн тухай албан ёсны тодорхойлолтыг үндэслэн ажиллуулах зохион байгуулалтын арга хэмжээ авах;

Дөрөв. Хууль зүй дотоод хэргийн дэд сайд С.Баатаржавт:

4.1. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд дэд сайд нар хуваарийн дагуу аймаг, дүүрэг хариуцаж цар тахалтай тэмцэх, зохион байгуулалтад дэмжлэг үзүүлэх ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэж, салбар дундын болон аймгуудын Онцгой комиссын ажлын уялдааг хангаж, анхан болон дунд шатны нэгжийн үйл ажиллагааны тулгамдсан асуудлыг тухай бүр шийдвэрлэж, мэдээ, мэдээллээр хангаж ажиллах;

Тав. Улсын онцгой комиссын гишүүн, Боловсрол шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгаланд:

5.1. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн 2020-2021 оны хичээлийн жилийн хичээл, сургалтын үйл ажиллагаанд зохицуулалт хийж, улирлын амралтыг эрт эхлүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авах, 2021-2022 оны хичээлийн жилийн хичээл, сургалтын үйл ажиллагааг танхимаар зохион байгуулах нарийвчилсан төлөвлөгөө боловсруулж, бэлтгэлийг хангаж ажиллах;

5.2. Ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар анги төгсөгчдийг элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх давтлагыг сургуулийн орчинд 2021 оны 5 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдүүлж, нэг сарын хугацаатай зохион байгуулах арга хэмжээ авах;

5.3. Их, дээд сургууль, коллежид элсэгчдээс авах элсэлтийн ерөнхий шалгалтыг 2021 оны 7 дугаар сарын 01-ээс 04-ний өдрүүдэд халдварын эрсдэлгүй зохион байгуулах бэлтгэл ажлыг сайтар хангах;

5.4. Гадаад улсын их, дээд сургууль, коллежид суралцах иргэдийн хэлний чадамж, мэдлэгийн түвшин тогтоох олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн шалгалтын төвүүдэд шалгалт зохион байгуулах зөвшөөрлийг Улсын онцгой комиссын Шуурхай штаб, мэргэжлийн байгууллагуултай зөвшилцөн олгож, хамтран хяналт тавих;

Шийдвэрийн биелэлтийг тооцож, танилцуулж ажиллахыг Улсын онцгой комиссын нарийн бичгийн дарга, хурандаа Ж.Амгалан, Шуурхай штабын дарга, хурандаа Ц.Ганзориг нарт даалгах.

ДАРГА С.АМАРСАЙХАН

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
ХУРАНДАА Ж.АМГАЛАН

